

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, холбогдох журмыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх, санхүүжүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т ДААЛГАХ нь:

2.1.Энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг хүлээн зөвшөөрсөн эмийн сантай гэрээ байгуулах, баталсан үнийн дээд хязгаарыг мөрдүүлэх, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн жагсаалтыг хүргэх мэдээлэх, сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулах;

2.2.Эрүүл мэндийн даатгалын цахим жорын системийн мэдээлэлд тулгуурлан даатгалын гэрээ бүхий эмийн санд тавих хяналтыг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах;

2.3.Жагсаалтад заасан ерөнхий нэршлийн эмийг худалдааны нэршил, эмийн бүртгэлийн дугаар, бар код бүрээр цахим програм хангамжид оруулах, бэлтгэл ажлыг хангах;

2.4.Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийг олгох, төсвийн үр ашгийг дээшлүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлж, тухай бүр тайлагнаж, арга хэмжээ авч ажиллах;

2.5. Энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн эмийг бичих эрхтэй эмчээр бичүүлэх, хэвшүүлэх, эмч нарт таниулах ажлыг зохион байгуулж, 2024 оны ... дүгээр сарын ... ний өдрөөс эхлэн мөрдүүлэх;

3.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (...)-т ДААЛГАХ нь:

- 3.1. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй чанарын баталгаатай эмийг зах зээлд нэвтрүүлэх, хүн амыг жигд, хүртээмжтэй хангах, чанар, аюулгүй байдлын хяналт тавих;
- 3.2. Эмийн зохистой хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэх, төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах;
- 3.3. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, эмийн зохицуулалтын үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэх;
4. Иргэн даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний цогц байдлыг хангах хүрээнд нийтэд зориулсан, эмнэлгийн гадуур эмийн санг бий болгож, эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчлэхийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ бүхий нийт эрүүл мэндийн байгууллагуудад үүрэг болгосугай
5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Т.Батмөнх/-нд даалгасугай.

ДАРГА

С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны ...дугаар сарын...-ны өдрийн ... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЖОРООР ОЛГОХ ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх, эмийн зохистой хэрэглээг дэмжих, цахим хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, оролцогч талуудын үүрэг оролцоог тодорхойлох, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зэрэг харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт (Цаашид "Эмийн үнийн хөнгөлөлт" гэнэ) үзүүлэх үйлчилгээ гэж Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Гааль татвар, санхүүгийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдэж Монгол Улсад худалдаалагдсан, олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөсөн, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан чанарын баталгаатай эмийг хөнгөлөлттэй үнээр даатгуулагчдад олгох, худалдаж авах харилцааг хэлнэ.

Хоёр. Оролцогч талуудын эрх, үүрэг

2.1. Даатгуулагчийн эрх, үүрэг:

- 2.1.1. Даатгуулагч нь даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр эм олгох үйлчилгээ авахдаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан эрүүл мэндийн байгууллагын жор бичих эрхтэй эмчид үзүүлж, эмчийн бичсэн "эмийн цахим жор"-оор гэрээ бүхий эмийн сангаар үйлчлүүлэх;
- 2.1.2. Даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламж үйлчилгээг авахдаа заавал эмчийн үзлэг хийлгэж оношлуулах бөгөөд үзлэг хийлгэсний дараа эмийн цахим жор бичүүлэх эрх үүснэ;
- 2.1.3. Хэвтрийн болон хүнд өвчтэй гэртээ байдаг даатгуулагчдад өрх, сум, тосгоны эмч нь гэрийн эргэлт, үзлэг хийх үедээ хурууны хээг баталгаажуулж эмийн цахим жорыг бичих бөгөөд асран хамгаалагчаар дамжуулж эмийн сангаас хөнгөлөлттэй эмийг авах;
- 2.1.4. Даатгуулагч нь эмийн цахим жорыг бичүүлэх үедээ өөрийн хурууны хээг уншуулж мэдээллээ үнэн зөв бүртгүүлэх үүрэгтэй;
- 2.1.5. Насанд хүрээгүй буюу хурууны хээний мэдээлэл иргэний бүртгэлийн нэгдсэн санд ороогүй хүүхдийг асран хамгаалагч нь, ажил мэргэжлийн онцлог болон бусад шалтгааны улмаас хурууны хээгүй, уншуулах боломжгүй иргэд хурууны хээ уншуулах боломжгүй иргэдийн нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдсэн бол хурууны хээ уншуулахгүй;

- 2.1.6. Даатгуулагч нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ"-г үндэслэн эмийн үнийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх, "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль"-д заасны дагуу төлбөрийн баримтыг эмийн сангаас авах;
- 2.1.7. Даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрх бүхий эмчээс эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн талаар болон эмийн хэрэглэх арга, үргэлжлэх хугацаа, гаж нөлөө, харилцан үйлчлэлийн талаар мэдээлэл авах;
- 2.1.8. Даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг шалгуулах, холбогдох мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдэд гомдол гаргах, шийдвэрлүүлэх;
- 2.1.9. Даатгуулагч нь хууль, журам, заавар зөрчсөн, чанарын шаардлага хангаагүй, хугацаа нь дууссан эмээр үйлчилсэн, тогтоолоор баталсан жагсаалт дахь үнийн дээд хязгаар, иргэний төлөх төлбөрийн хэмжээг хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан эмийн сангийн талаар холбогдох хяналт шалгалтын болон эрүүл мэндийн даатгалын байгууллагад хандах, мэдээлэл өгөх, эрх ашгаа хамгаалуулах;
- 2.1.10. Даатгуулагч нь жорын стандартын дагуу заагдсан хөнгөлөлттэй эмийн цахим жорын хүчинтэй хугацааг дуусахаас өмнө даатгалын газартай гэрээ бүхий хөнгөлөлттэй эмийг худалдан авах;

2.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрх, үүрэг:

- 2.2.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл сонгох, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ тогтоох аргачлал"-ын дагуу эрүүл мэндийн байгууллага, даатгуулагч болон бусад холбогдох байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээг тогтоох, өөрчлөх талаар саналд дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, жагсаалтыг шинэчлэх талаар ажиллах;
- 2.2.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардлын төсвийн төслийг даатгуулагчийн тоо, өвчлөлийн байдал, эмийн зах зээлийн үнэ, тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх онуудын гүйцэтгэл, зөвшөөрөл бүхий эмийн сангийн тоо болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн боловсруулж, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх;
- 2.2.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад хүсэлт ирүүлсэн эмийн сантай "Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ" байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний биелэлтээс хамаарч гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар шийдвэр гаргах, олон нийтэд мэдээллэх;

- 2.2.4. Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох зардлыг гэрээнд заасан хугацаанд эмийн сангуудаас ирсэн цахим нэхэмжлэлд үндэслэн эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг гүйцэтгэлээр тооцон санхүүжүүлэх;
- 2.2.5. Даатгуулагч болон эрүүл мэндийн байгууллага, эрх бүхий эмч нараас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, даатгалын харилцаанд оролцогч талуудыг мэдээллээр ханган ажиллах;
- 2.2.6. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх цахим жор бичих эрх бүхий эмч, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эрүүл мэндийн даатгалын байгууллага хооронд мэдээллийн цахим тогтолцоог нэвтрүүлэх, тавих хяналтыг сайжруулах;
- 2.2.7. Эмийн үнийн хөнгөлөлтийн тайлан, мэдээнд судалгаа хийж судалгааны үр дүнд үндэслэн холбогдох шийдвэрийг гаргах;
- 2.2.8. Эрүүл мэндийн даатгалын байцаагч, мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагын талаар болон ашиг сонирхлын зөрчлийн талаар эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн гомдлыг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;
- 2.2.9. Гэрээ бүхий эмийн сан болон эрх бүхий эмч нарын буруутай үйл ажиллагааны улмаас даатгуулагчдад болон эрүүл мэндийн даатгалын санд хохирол учруулсан нь тогтоогдвол Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хохирлыг албан тушаалтан болон хуулийн этгээдээр төлүүлэх;
- 2.2.10. Жор бичих эрх бүхий эмч нарт даатгуулагчдад үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн цахим жор бичих "Эрүүл мэндийн даатгалын цахим систем"-д нэвтрэх эрх нээх, хаах асуудлыг хариуцах;
- 2.2.11. Журмын 2.2.10-т заасан нэвтрэх эрхийг тухайн эрүүл мэндийн байгууллагаас цахим хэлбэрээр эрүүл мэндийн даатгалын байгууллагад хүргүүлж, цахимаар шийдвэрлүүлэх;
- 2.2.12. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

2.3. Даатгуулагчдад үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн цахим жор бичих эмч, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг:

- 2.3.1. Эрүүл мэндийн байгууллага, эмч нь даатгуулагчдад мэргэжлийн дагуу үзлэг хийж, даатгуулагчийн хурууны хээний баталгаажуулалт дээр үндэслэн цахим жорыг бичих бөгөөд жор бичсэн эмч мөн хурууны хээний баталгаажуулалт давхар хийснээр цахим жор хүчинтэй болох;
- 2.3.2. Байнгын эм уух шаардлагатай архаг оноштой даатгуулагчдад хяналтын үзлэг хийсний дараагаар, анх удаа тухайн оношоор оношлогдож байгаа даатгуулагчдад анхан үзлэг, онош баталгаажуулах оношилгоо, шинжилгээ хийж давтан үзлэг хийгдсэний дараа хөнгөлөлттэй эмийн цахим жор бичих;
- 2.3.3. Эмч нь даатгуулагчийн өвчний карт болон эмнэлзүйн оношийг баталгаажуулах бусад баримтад үндэслэн шаардлагатай тохиолдолд үндсэн харьяаллаас өөр дүүрэг аймаг, нийслэл, суманд байхаас үл хамааран эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх цахим жорыг харьяалал харгалзахгүй бичих;

- 2.3.4. Жор бичих эрх бүхий эмч нь даатгуулагчид хийх үзлэгийн хугацааг 15 минутаас доошгүй байх зарчмыг баримталж ажиллах бөгөөд эрүүл мэндийн байгууллага хяналтыг давхар хийх;
- 2.3.5. Даатгуулагчдад хөнгөлөлттэй эмийн цахим жор бичихдээ "Эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2016 стандарт, эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасны дагуу олон улсын эмнэлзүйн удирдамжийг баримтлан бичих;
- 2.3.6. Цахим жор бичих эрх бүхий эмч нь даатгуулагчид эмийн фармакологийн үйлдэл, тун болон хэлбэрийг давхцуулалгүй бичих;
- 2.3.7. Эмч нь цахим жорын тэмдэглэл хэсэгт даатгуулагчид хийсэн үзлэгийн тэмдэглэлийг тодорхой тусгах;
- 2.3.8. Эмийн жоронд заасан эмийн хэрэглэх хугацаа нь олон улсын эмнэлзүйн удирдамжид заасны дагуу эмчилгээний нийт тун, хоногийн нийт тунгийн хэмжээтэй уялдсан байх бөгөөд цахим системээр хязгаарлалтын хүрээнд ажиллана;
- 2.3.9. Эмч нь хөнгөлөлттэй эмийн жагсаалтад байх мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмийн жорыг "Эмийн жорын маягт, жор бичилт" MNS 5376:2016 стандартын дагуу цахим болон цаасан жорын маягтад давхар бичих;
- 2.3.10. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ болон гэрээ бүхий эмийн сангуудын талаар иргэд, даатгуулагчийг үнэн зөв мэдээллээр ханган ажиллах;
- 2.3.11. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нь өөрийн харьяалал бүхий даатгуулагчдыг дараах өвчний үед хэрэглэх эмийг лавлагаа шатлалын эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмийг хэрэглэх тунгийн дагуу тасралтгүй хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавина, Үүнд:
- 2.3.10.1. Артерийн даралт ихсэх өвчин болон бусад архаг зүрх судасны эмгэгүүд
- 2.3.10.2. Чихрийн шижин болон бусад дотоод архаг дотоод шүүрлийн эмгэгүүд
- 2.3.10.3. Уналт таталт болон бусад архаг мэдрэл, булчингийн гаралтай эмгэгүүд
- 2.3.10.4. Сэтгэцийн эмгэгүүд
- 2.3.10.5. Вирусын гаралтай гепатит болон элэгний хатуурал
- 2.3.10.6. Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах байдал
- 2.3.10.7. Бүх төрлийн хорт хавдар болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ
- 2.3.12. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

2.4. Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх эмийн сангийн эрх, үүрэг:

- 2.4.1. Эмийн сан нь Эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн системд холбогдох, эмийн сангийн санхүүгийн болон эмийн бүртгэлийн цахим

- програм хангамжийг бүрэн ашигладаг байх, цахим программ хангамжийн хөгжүүлэлтийг тухай бүрт нь шуурхай хийдэг байх;
- 2.4.2. Эмийн сан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх жагсаалтанд заасан үнийн дээд хязгаараас доогуур үнээр эмээ борлуулж буй тохиолдолд тухайн доогуур үнээр тооцож иргэнээс иргэний төлөх төлбөр авах;
 - 2.4.3. Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, эмийн сангийн стандарт шаардлагуудыг бүрэн хангасан байх;
 - 2.4.4. Эмийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан эм зүйч тогтмол удирдах, дотоодын хяналт тавих, цаашид тогтвортой ажиллах санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх;
 - 2.4.5. Эмийн сан нь эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээллийг даатгуулагчдад харагдахуйц газар ил, тод байрлуулах;
 - 2.4.6. Эмчийн бичсэн цахим жорын дагуу даатгуулагчийн иргэний үнэмлэхийг үндэслэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх;
 - 2.4.7. Хэвтрийн болон хүнд өвчтэй эмийн санд өөрийн биеэр ирэх боломжгүй даатгуулагчийн хувьд асран хамгаалагч нь даатгуулагчийн иргэний үнэмлэхийг эмийн санд үзүүлж эмээ авах;
 - 2.4.8. Эмийн сан нь даатгуулагчид түүний овог, нэр, регистрийн дугаар, эмчийн шифр, жорын код, огноо, эмийн нэр, тоо ширхэг, эмийн тун, нэг хайрцаг дахь савлагааны тоо, эмийн нийт үнэ үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчийн төлсөн төлбөрийн хэмжээг багтаасан "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль"-д заасны дагуу төлбөрийн баримтын хувийг даатгуулагчид тухай бүрт олгох;
 - 2.4.9. Эмийн сан нь даатгуулагчид цахим жороор үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг гэрээний дагуу тогтоосон хугацаанд эрүүл мэндийн даатгалын байгууллагад цахимаар илгээх;
 - 2.4.10. Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг хагас, бүтэн жилээр эрүүл мэндийн даатгалын байгууллагатай тооцоо нийлэх;
 - 2.4.11. Эмийн сан нь эмийн сангийн хаяг, байршил, талбайн хэмжээ, хүний нөөцөд өөрчлөлт орсон тохиолдолд эрүүл мэндийн даатгалын байгууллагад албан бичгээр ажлын 10 хоногийн дотор мэдэгдэх;
 - 2.4.12. Эмийн сангийн стандартад заасан анхан шатны болон санхүүгийн баримтыг холбогдох хууль, журмын дагуу архивын нэгж болгон хадгалах;
 - 2.4.13. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг үнэн зөв, тогтоосон хугацаанд гаргах, өр авлага үүсгэхгүй байх;
 - 2.4.14. Үйлчлүүлэгчийн санал хүсэлт, эмийн цахим програм хангамжийн талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх;
 - 2.4.15. Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал гаргах;

- 2.4.16.Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн байгууллага, даатгуулагч иргэдийн ёс зүй, харьцаа хандлагын талаар гомдол гаргах;
- 2.4.17.Эмийн жоронд бичигдсэн эмийг хэрэглэх хугацааны дагуу даатгуулагчид хүндрэл чирэгдэлгүй олгох;
- 2.4.18.Даатгуулагчийг эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, иргэний төлөх төлбөр, холбогдох хууль, тогтоомж, журам, даатгалын байгууллагын бусад үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллээр хангах;
- 2.4.19. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Гурав. Хориглох зүйл

3.1. Даатгалын гэрээ бүхий эмийн санд хориглох зүйл:

- 3.1.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг хэтрүүлэх, илүү төлбөр авах, "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль"-д заасны дагуу төлбөрийн баримтыг олгохгүй байх;
- 3.1.2.Эмийн сангийн анхан шатны бүртгэл мэдээ, эмийн нэр төрөл, орлого, зарлагын баримт, тайланг буруу буюу дутуу хөтлөх, эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх;
- 3.1.3.Эм барих зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд оролцуулах;
- 3.1.4. Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлгүй, хуурамч, чанарын баталгаагүй, хугацаа дууссан эмээр үйлчлэх;
- 3.1.5.Ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эмч, иргэнтэй хуйвалдан эм борлуулах, үр дүнгээр урамшуулах, түүнтэй адилтгах үйл ажиллагаанд татан оролцуулах, эмийг худалдааны нэршлээр даатгуулагчид илт санал болгож, сонголтыг хязгаарлах;
- 3.1.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг зөрчин зар сурталчилгаа явуулах, тулган шаардах, буруу ташаа мэдээлэл өгөх, үйлчлүүлэгчийн сонгох боломжийг хязгаарлах;
- 3.1.7.Эрүүл мэндийн даатгалын байгууллагад эмийн сангийн стандарт, санхүүгийн болон хүний нөөц, бусад асуудлаар худал мэдээлэл ирүүлэх, байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;
- 3.1.8.Төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, төөрөгдүүлэх, шалгалтад холбогдолтой баримт бичгийг засварлах, гэмтээх, устгах, шалгалтаас зайлсхийх, хуурамч баримт бичиг гаргаж өгөх;

3.2. Даатгуулагчдад үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор бичих эмч, эрүүл мэндийн байгууллагад хориглох зүйл:

- 3.2.1.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасан олон улсын эмнэлзүйн удирдамжийг баримтлахгүйгээр даатгуулагчийн өвчний онош, нас, хүйсэнд тохироогүй эм бичих;

- 3.2.2.Эмч үзлэг, оношилгоо, шинжилгээ хийхгүйгээр даатгуулагчид эмийн жор бичих;
- 3.2.3.Эрүүл мэндийн даатгалын цахим системд нэвтрэх эрх болон эмчийн шифрийг өөр хүнд ашиглуулах;
- 3.2.4.Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан болон тэдгээрийн холбоо бүхий хүмүүсээс аливаа эмийг жоронд бичсэн гүйцэтгэлд үндэслэн санхүүгийн болон материаллаг урамшуулал авах, эмийг сурталчлах, худалдах;
- 3.2.5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор бичих;
- 3.2.6.Жор бичих эрхтэй эмч нь тухайн эрүүл мэндийн байгууллагаас гарсан үед жор бичих эрхийг түтгэлзүүлэх цахим хүсэлтийг илгээхгүй байх.
- 3.2.7.Хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх бүхий эмч нь өөртөө, өөрийн хамаарал бүхий этгээд, төрөл садан, хамтран ажиллагчдаа аливаа эмнэлзүйн оношийн үндэслэлгүйгээр жор бичиж эмийн сангийн ашиг орлогыг хийсвэрээр нэмэгдүүлэх, даатгалын санг санаатайгаар хохироох, хувьдаа завших;

3.3. Даатгуулагчид хориглох зүйл:

- 3.3.1.Энэхүү журмын 2.1.5-д дурьдсан даатгуулагчид тухайн заалтыг хэрэгжүүлэхгүй байх;
- 3.3.2.Эмчид үзүүлэхгүйгээр, мөн шаардлагагүй эм бичихийг эмчээс шаардах;
- 3.3.3.Эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсэргүүцэх, нэр хүндийг гутаан доромжлох, гүтгэх, худал мэдээллийг тараах, төөрөгдүүлэх, нийтэд дэлгэх.
- 3.3.4.Эмч, эмийн сантай үгсэн хуйвалдаж эрүүл мэндийн даатгалын санг хохироох үйлдэл хийх;

Дөрөв. Хариуцлага

- 4.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;
- 4.2. Эмийн сан нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс удаа дараалан гомдол ирүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийг арилтал санхүүжилтийг түдгэлзүүлэх, дээрх зөрчил давтан илэрсэн, хуурамч баримт бичгээр санхүүжилт авсан нь нотлогдсон тохиолдолд гэрээг цуцлах, эрүүл мэндийн даатгалын санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авах;
- 4.3. Тус журмын хориглох хэсгийг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эмийн сан хооронд байгуулсан гэрээг цуцлах, тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагад эрүүл мэндийн даатгалын байгууллагын зүгээс гомдол санал хүргүүлж арга хэмжээ авхуулах;
- 4.4. Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх цахим жор бичих эрх бүхий эмч нар энэхүү журмыг зөрчсөн, даатгуулагч иргэдээс ирүүлсэн гомдол нь үндэслэлтэй нь

нотлогдсон тохиолдолд тухайн эмчийн "эрүүл мэндийн даатгалын цахим систем"-д нэвтрэх эрхийг хааж, эрүүл мэндийн байгууллагын амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний зардлын төлбөрийг бууруулах, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч олон нийтэд мэдээллэх;

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны ...дугаар сарын...
-ны өдрийн ... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН НЭР ТӨРӨЛ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР, ХӨНГӨЛӨХ ХЭМЖЭЭ

Д/д	Эмийн АТС код	Эмийн ерөнхий нэршил /ЭМД-ын дугаар	Эмийн олон улсын нэршил /ЭОУН/	Эмийн олон улсын нэршил /ЭОУН/	Эмийн хэлбэр	Савлалтын тун	Худалдааны нэр	Эмийг бичих эрхтэй эмчийн ангилал	Эмийг хэрэглэх хүн амын бүлэг	Өвчний олон улсын 10-р ангиллын код /ICD10/	Эмийн бар код	Үнийн дээд хязгаар төгрөгөөр /ширхэг/	ЭМД-ын сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээ төгрөгөөр
1	L04AX01	1	азатиоприн	Azathioprine	шахмал	50мг	Иммутера	С, D	том хүн, хүүхэд	M11;J62;J63;N03;K74;K75.4;H20	8656000200074	649	454
2	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	250мг	Азитро Денк 250	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	4031571070341	2,480	1736
3	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Зитролин	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8994841000355	1,800	900
4	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Азибиот	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3838989637422	3,940	1970
5	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Азибру-500	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8902399007375	2,500	1250
6	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Азитро-Денк	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	4031571070358	4,820	2410
7	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Азитромицин Лек	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3838957016877	4,760	2380
8	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Азитромицин	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	5017007055518	17,114	5134
9	J01FA10	2	азитромицин	azithromycin	бүрхүүлтэй шахмал	500мг	Азитрон	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8656020989737	2,030	1015
10	J01FA10	2	азитромицин	azithromycin	капсул	250мг	Азитрон	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8656898966205	900	450
11	J01FA10	2	азитромицин	azithromycin	капсул	250мг	Флоктл 250	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8853935030725	1,410	705
12	J01FA10	2	азитромицин	azithromycin	капсул	500мг	Азитровис	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3800714233001	5,863	4104
13	J01FA10	2	азитромицин	azithromycin	ууж хэрэглэх хөвмөл	100мг-5мл	Азитровис	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3800221293345	21,021	14715
14	J01FA10	2	азитромицин	azithromycin	ууж хэрэглэх хөвмөл	200мг-5мл	Азибиот	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3838989709617	16,522	11565
15	J01FA10	2	азитромицин	azithromycin	ууж хэрэглэх хөвмөл	200мг-5мл	Девази	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	18906047544455	17,550	8775
16	J01FA10	2	азитромицин	azithromycin	ууж хэрэглэх хөвмөл	200мг-5мл	Азитровис	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3800221293352	22,880	6864
17	J01FA10	2	азитромицин	azithromycin	ууж хэрэглэх хөвмөл	200мг-5мл	Азитромицин Лек	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	3838957017959	21,307	10654
18	J01FA10	2	азитромицин	azithromycin	шахмал	250мг	Корзит	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8904151815938	1,200	600
19	J01FA10	2	азитромицин	azithromycin	шахмал	250мг	Азитромицин 250мг шахмал	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	2019129760250	1,208	604
20	J01FA10	2	азитромицин	azithromycin	шахмал	500мг	Корзит	В, С, D	том хүн	H72;J18;J35;J40;J41;J47;L04;L50;N34;N73;J01;J20;J21;J22;J39	8904151813668	2,800	1960
21	A02BC05	3	аллопуринол	allopurinol	шахмал	100мг	Ланпурин	С, D	том хүн, хүүхэд	M11	8994757000470	110	77
22	R03DA05	4	Аминофиллин	Aminophylline	шахмал	150мг	Эуфиллин	В, С, D	том хүн	J44	4603276005418	50	35
23	C01BD01	5	амиодарон	Amiodarone	шахмал	200мг	Амиокордун	В, С, D	том хүн	I48;I49.9;I50	3838989521455	460	322
24	N06AA09	6	Амитриптилин	Amitriptyline	бүрхүүлтэй шахмал	10мг	Амитриптилин - Гриндекс	В, С, D	том хүн, хүүхэд	K30;G47;G55;G56;G58;G59;H81;N36	4750232002995	220	154
25	N06AA09	6	Амитриптилин	Amitriptyline	бүрхүүлтэй шахмал	25мг	Амитриптилин - Гриндекс	В, С, D	том хүн, хүүхэд	K30;G47;G55;G56;G58;G59;H81;N36	4750232005156	240	168
26	N06AA09	6	Амитриптилин	Amitriptyline	шахмал	25мг	Амитриптилин	В, С, D	том хүн, хүүхэд	K30;G47;G55;G56;G58;G59;H81;N36	4602676003390	250	175
27	C08CA01	7	Амлодипин	amlodipine	шахмал	10мг	Амлодипин	В, С, D	том хүн	I10;I11;I12;I25	7401066201050	146	146
28	C08CA01	7	Амлодипин	amlodipine	шахмал	5мг	Амлодипин	В, С, D	том хүн	I10;I11;I12;I25	7401066201043	131	131
29	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг	Бифорже	В, С, D	том хүн	I10;I11;I12	8806429048713	1,480	740
30	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг	Вамлосет	В, С, D	том хүн	I10;I11;I12	4610017700709	1,120	560
31	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг	Эксфорж	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797295533	1,600	800
32	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг	Хифорже	В, С, D	том хүн	I10;I11;I12	8809533817374	8,617	2585
33	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг	Эксфорж	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797504192	2,022	1011
34	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг	Эксфорж	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797712887	2,022	1011

35	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	5мг+160мг	Вамлосет	В, С, D	том хүн	I10;I11;I12	4610017700716	1,080	756
36	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	5мг+160мг	Эксфорж	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797295540	1,620	810
37	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	5мг+160мг	Эксфорж	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797504185	2,048	1024
38	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	5мг+80мг	Бифорже	В, С, D	том хүн	I10;I11;I12	8806429048515	1,200	600
39	C09DB01	8	Амлодипин + Валсартан	Amlodipine+Valsartan	бүрхүүлтэй шахмал	5мг+80мг	Вамлосет	В, С, D	том хүн	I10;I11;I12	4610017700723	770	385
40	C09DX01	9	Амлодипин + Валсартан + Гидрохлоротиазид	Amlodipine+Valsartan+Hydr ochlorothiazide	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг+12.5мг	Ко-Вамлосет	В, С, D	том хүн	I10;I11;I12	3838989735012	1,050	525
41	C09DX01	9	Амлодипин + Валсартан + Гидрохлоротиазид	Amlodipine+Valsartan+Hydr ochlorothiazide	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг+12.5мг	Эксфорж Н	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797495902	1,850	925
42	C09DX01	9	Амлодипин + Валсартан + Гидрохлоротиазид	Amlodipine+Valsartan+Hydr ochlorothiazide	бүрхүүлтэй шахмал	10мг+160мг+25мг	Ко-Вамлосет	В, С, D	том хүн	I10;I11;I12	3838989735647	1,350	945
43	C09DX01	9	Амлодипин + Валсартан + Гидрохлоротиазид	Amlodipine+Valsartan+Hydr ochlorothiazide	бүрхүүлтэй шахмал	5мг+160мг+12.5мг	Ко-Вамлосет	В, С, D	том хүн	I10;I11;I12	3838989735029	1,000	500
44	C09DX01	9	Амлодипин + Валсартан + Гидрохлоротиазид	Amlodipine+Valsartan+Hydr ochlorothiazide	бүрхүүлтэй шахмал	5мг+160мг+12.5мг	Эксфорж Н	В, С, D	том хүн	I10;I11;I12	7612797495896	1,800	900
45	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	10мг+20мг	Амлизект	В, С, D	том хүн	I10;I11;I12	5310090006062	1,665	833
46	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	10мг+20мг	Экватор	В, С, D	том хүн	I10;I11;I12	5997001362242	1,670	835
47	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	10мг+20мг	Экватор	В, С, D	том хүн	I10;I11;I12	5997001363133	1,670	835
48	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	20мг+5мг	Экватор	В, С, D	том хүн	I10;I11;I12	5997001363386	935	654
49	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	5мг+10мг	Амлизект	В, С, D	том хүн	I10;I11;I12	5310090009612	1,030	721
50	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	5мг+10мг	Экватор	В, С, D	том хүн	I10;I11;I12	5997001360828	1,150	575
51	C09BB03	10	Амлодипин + Лизиноприл	Amlodipine + Lisinopril	шахмал	5мг+10мг	Экватор	В, С, D	том хүн	I10;I11;I12	5997001360859	1,150	575
52	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	бүрхүүлтэй шахмал	500мг	Оспамакс 500	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	9002260010585	1,150	805
53	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Амоксален 500	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	5290665001237	220	110
54	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Амокси-БКРС	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8908003345857	160	80
55	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Амоксциллин	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	6939007635356	180	90
56	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Амоксциллин	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8654000080115	120	60
57	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Амоксциллин	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8656898949208	210	105
58	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Моксилен	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	5290931002258	170	85
59	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Бактокс	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	3400970000623	534	160
60	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	капсул	500мг	Амоксциллин	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8654000090039	220	110
61	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	ууж хэрэглэх хөвмөл	125мг-5мл	Бактокс	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	3400970000593	5,244	3671
62	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	ууж хэрэглэх хөвмөл	250мг-5мл	Бактокс	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	3400970000586	6,494	3247
63	J01CA04	11	амоксциллин	amoxicillin	ууж хэрэглэх хөвмөл	250мг-5мл	Амокси Т.О. Драй форте	А, В, С, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8851881608401	2,498	1249

64	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	ууж хэрэглэх хөвмөл	250мг-5мл	Осламокс	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	9002260003747	38,203	11461
65	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	ууж хэрэглэх хөвмөл	250мг-5мл	Хиконцил	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	3838989517243	7,672	3836
66	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	уусдаг шахмал	125мг	Флемоксин Солутаб	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	4607098450159	761	381
67	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	уусдаг шахмал	125мг	Медомокс 125 ДТ	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8904065005241	420	210
68	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	уусдаг шахмал	250мг	Амоксициллин	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	7401066202095	131	131
69	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	уусдаг шахмал	500мг	Флемоксин Солутаб	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	4607098450197	1,180	826
70	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	шахмал	500мг	Виамокс	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	8994757000449	280	140
71	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	шахмал	500мг	Амокси-Денк 500	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	4031571048340	1,567	783
72	J01CA04	11	амоксициллин	amoxicillin	капсул	500мг	Хиконцил	A, B, C, D	хүүхэд	H72;I33.0;J02;J13;J47;K29.3;L03;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;N86;J01;J20;J21;J22;J39	3838989541705	610	183
73	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй каплет	500мг+125мг	Вигентин	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	8934903002170	1,200	840
74	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	250мг+125мг	Клавамид 375	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	5290665003453	1,000	500
75	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	250мг+125мг	Амоксициллин + Клавулоны хүчил	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	6921875008592	7,259	3629
76	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	375мг	Моксиклав	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	5290931000902	1,390	973
77	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	500мг+125мг	Клавамид 625	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	5290665002869	1,100	550
78	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	500мг+125мг	Моксиклав	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	5290931000896	2,000	1000
79	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	500мг+125мг	Амоксиклав	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	3838957073931	3,350	1005
80	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	500мг+125мг	Аугмекс	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	8806044012113	620	434
81	J01CA04	12	Амоксициллин + Клавуланы хүчил	amoxicillin + clavulanic acid	бүрхүүлтэй шахмал	500мг+62.5мг	Амоксиклав - денк 500/62.5	B, C, D	том хүн, хүүхэд	H72;H92;J12;J14;J35;J41;J47;K10;L03;N11;N30;H93;N13;N15;N16;N20;N21;N22;N23;N28;J01;J20;J21;J22;J39	4031571053993	1,881	1316
589	R03DA04	131	Теофиллин эфедрин	Theophylline	капсул	200мг	Теотард	D	том хүн	J41;J44;J45	3838989528133	310	217
590	R03DA04	131	Теофиллин эфедрин	Theophylline	капсул	350мг	Теотард	D	том хүн	J41;J44;J45	3838989528140	547	383
591	S01ED01	132	тимолол	timolol	нүдний дусал	0.005мг	Ауротим	B, C, D	том хүн	H40;H40.1	8903878031875	13,700	9590
592	S01ED01	132	тимолол	timolol	нүдний дусал	0.25%-5мл	Тимолол-Акос	B, C, D	том хүн	H40;H40.1	4602565007300	2,900	2030
593	S01ED01	132	тимолол	timolol	нүдний дусал	0.5%-5мл	Тимолол малеат	B, C, D	том хүн	H40;H40.1	7612797498378	10,500	5250
594	S01ED01	132	тимолол	timolol	нүдний дусал	0.5%-5мл	Тимолол-Акос	B, C, D	том хүн	H40;H40.1	4602565007317	3,600	1800
595	S01AA12	133	тобрамицин	tobramycin	нүдний дусал	0.003мг	Тобрекс	C, D	том хүн	H60	5413895027093	17,500	8750
596	S01AA12	133	тобрамицин	tobramycin	нүдний дусал	0.003мг	Тобрекс	C, D	том хүн	H60	7612797498446	17,875	8938
597	S01AA12	133	Тобрамицин	tobramycin	нүдний дусал	0.3%-5мл	Тобрамицин	C, D	том хүн	H60	2019039760142	6,500	4550
598	N03AX11	134	Топирамат	topiramate	бүрхүүлтэй шахмал	25мг	Торамат	B, C, D	том хүн, хүүхэд	G10;G11;G12;G40;G41;G43;G44	5206901004122	900	630
599	N03AX11	134	Топирамат	topiramate	бүрхүүлтэй шахмал	50мг	Торамат	B, C, D	том хүн, хүүхэд	G10;G11;G12;G40;G41;G43;G44	5206901004139	1,200	840
600	C03CA04	135	торасемид	torsemide	шахмал	10мг	Торас-Денк 10	B, C, D	том хүн	I11;I50	4031571068812	940	658
601	C03CA04	135	торасемид	torsemide	шахмал	5мг	Торас-Денк 5	B, C, D	том хүн	I11;I50	4031571068850	500	250
602	C03CA04	135	торасемид	torsemide	шахмал	5мг	Торас-Денк 5	B, C, D	том хүн	I11;I50	4031571052439	838	419
603	B02AA02	136	Триамцинолон	Triamcinolone	тосон түрхлэг	0.001мг	Кено орал паста	B, C, D	том хүн	K12;J01;J20;J21;J22;J39	8851881704608	4,069	2848
604	D07AB09	136	Триамцинолон	Triamcinolone	тосон түрхлэг	0.001мг	Кено орал паста	B, C, D	том хүн	K12;J01;J20;J21;J22;J39	8851881704615	6,730	3365
605	D07AB09	136	Триамцинолон	Triamcinolone	тосон түрхлэг	0.001мг	Кено орал паста	B, C, D	том хүн	K12;J01;J20;J21;J22;J39	8851881704622	6,500	3250
606	D07AB09	136	Триамцинолон	Triamcinolone	тосон түрхлэг	0.001мг	Орамеди тосон түрхлэг	B, C, D	том хүн	K12;J01;J20;J21;J22;J39	8806534007926	10,850	3255
607	C01EB15	137	триметазидин	trimetazidine	бүрхүүлтэй шахмал	35мг	Предизин	A, B, C, D	том хүн	I01;I25	5997001309650	440	220
608	C01EB15	137	триметазидин	trimetazidine	бүрхүүлтэй шахмал	35мг	Предизин	A, B, C, D	том хүн	I01;I25	5997001302316	550	275
609	C01EB15	137	триметазидин	trimetazidine	уртасгасан үйлдэлтэй	35мг	Пресин-35	A, B, C, D	том хүн	I01;I25	6921875012568	378	265
610	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	ууж хэрэглэх хөвмөл	200мг+40мг-5мл	Санлрима	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	8992008300147	2,200	1540
611	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	200мг+40мг-5мл	Трисептол	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	8656898975207	394	276
612	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	400мг+80мг	Бидисептол	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	8934680110336	343	105
613	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	400мг+80мг	Ко-Тримексазол	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	865400090145	126	63
614	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	400мг+80мг	Котримоксазол шахмал	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	2019039760357	106	74
615	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	400мг+80мг	Тримексазол 480мг	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	8656898920207	220	110
616	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	400мг+80мг	Трисептол	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	8656898977201	250	125
617	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	480г	Тримексазол	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	8654000081327	180	126
618	J01EE01	138	триметоприм + сульфаметоксазол	trimethoprim + sulfamethoxazole	шахмал	480мг	Котримоксазол	A, B, C, D	том хүн	I33.0;L03;N30;N61;N75;S07;S08;S17;S18;S26;S27;S28;S36;S37;N41;N42;N44;N45;N64	6939007606202	100	70
619	A05AA02	139	Урсодоэкохильон хүчил	ursodeoxycholic acid	бүрхүүлтэй шахмал	300мг	Уколик	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8806625040610	1,050	735

620	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	200мг	Урсомон	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8656020989270	1,160	812
621	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урса	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	4806521640253	1,500	750
622	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урсобил	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8022086001674	1,200	600
623	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урсокапс	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	4810046030066	1,100	550
624	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урсомон	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8656020989065	1,100	550
625	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урссосан	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8595026463226	1,230	615
626	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урссосан	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8595026463950	1,310	655
627	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урсофальк	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	4032717001045	1,800	540
628	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	250мг	Урссосан	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8595026463356	1,310	655
629	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	300мг	Урссосан	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8656020989447	1,200	840
630	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	500мг	Урсобил	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8022086001681	2,800	1960
631	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	капсул	50мг	Урсомон 50мг	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8656020989454	611	428
632	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	шахмал	100мг	Урдестон Таб.100	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	14987155121114	690	345
633	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	шахмал	100мг	Урдестон Таб.100	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	14987155121145	867	434
634	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	шахмал	200мг	Урса	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8656021044077	1,400	700
635	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	шахмал	200мг	Урса	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8806416020630	1,400	700
636	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	шахмал	200мг	Урссосан	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8806443027138	923	646
637	A05AA02	139	Урсодоэкохильн хүчил	ursodeoxycholic acid	шахмал	300мг	Юдипел форте	B, C, D	том хүн	B18.0;B18.1;B18.2;K74	8901815002314	1,350	945
638	A02BA03	140	фамотидин	famotidine	бүрхүүлтэй шахмал	20мг	Фамоцид 20	B, C, D	том хүн	K26;K25;K21	8993008320015	150	105
639	N03AA02	141	фенобарбитал	phenobarbital	шахмал	100мг	Барбитал	B, C, D	том хүн, хүүхэд	G10;G11;G12;G40;G41;G43;G44	8656020989843	590	413
640	N03AA02	141	фенобарбитал	phenobarbital	шахмал	5мг	Барбитал	B, C, D	том хүн, хүүхэд	G10;G11;G12;G40;G41;G43;G44	8656020989836	390	273
641	C10AB05	142	фенофибрат	fenofibrate	бүрхүүлтэй каплет	160мг	Фенофибрат-ОТТО	C, D	том хүн	G10;G11;G12;G40;G41;G43;G44	8994841000799	1,100	770
642	D01AC15	143	Флуконазол	Fluconazole	капсул	100мг	Флукона-Денк	B, C, D	том хүн, хүүхэд	B35;B37;B38;B39;B40;B45;L21	4031571063763	4,320	3024
643	D01AC15	143	Флуконазол	Fluconazole	капсул	150мг	Флуконазол СТЕЛЛА	B, C, D	том хүн, хүүхэд	B35;B37;B38;B39;B40;B45;L21	8936106321072	1,095	548
644	D01AC15	143	Флуконазол	Fluconazole	капсул	150мг	Флукона-Денк 150	B, C, D	том хүн, хүүхэд	B35;B37;B38;B39;B40;B45;L21	4031571063787	13,600	6800
645	C03CA01	144	Флуоксетин	Fluoxetine	капсул	20мг	Фоксетин	D	том хүн, хүүхэд	F06.3;F25.1;F25.2;F31;F33	8806572009913	480	336
646	R03BA05	145	флутиказон	fluticasone	хамрын цацлага	50мкг/тун-120тун	Флуназ Усан суурьтай Хамрын Цацлага	C, D	том хүн	J41;J44;J45;J01;J20;J21;J22;J39	4716140051708	28,000	19600
647	R03AC13	146	формотерол	formoterol	ингаляцийн нунтаг	0.012мг	Зэфирон	D	том хүн	J41;J44;J45	5909990975914	99,000	69300
648	J01XH01	147	Фосфомоцилин	Fosfomycin	ууж хэрэглэх уусмал	3000мг	Монурал	C, D	том хүн	H72;J18;J40;J41;J47;K25;K29.3;N41;N42	4603619000155	28,554	14277
649	J01XH01	147	Фосфомоцилин	Fosfomycin	ууж хэрэглэх уусмал	3000мг	Цисторал	C, D	том хүн	H72;J18;J40;J41;J47;K25;K29.3;N41;N42	4820135586400	16,956	8478
650	J01XH01	147	Фосфомоцилин	Fosfomycin	ууж хэрэглэх хөвмөл	3000мг	Цисто	C, D	том хүн	H72;J18;J40;J41;J47;K25;K29.3;N41;N42	8806625039522	10,633	5317
651	J01XH01	147	Фосфомоцилин	Fosfomycin	ууж хэрэглэх хөвмөл	3000мг	Уржер	C, D	том хүн	H72;J18;J40;J41;J47;K25;K29.3;N41;N42	8699580240016	7,271	3636
652	C03CA01	148	фуросемид	furosemide	шахмал	40мг	Фуросемид	A, B, C, D	том хүн	I05;I07;I10;I50	7401066202088	131	131
653	M01AH01	149	целекоксиб	Celecoxib	капсул	100мг	Дилакса	C, D	том хүн	K56;K80;M11;M15;M16;M17;M18;M19;M45;N80	3838989656560	1,645	823
654	M01AH01	149	целекоксиб	Celecoxib	капсул	100мг	Дилакса	C, D	том хүн	K56;K80;M11;M15;M16;M17;M18;M19;M45;N80	3838989656584	1,770	885
655	M01AH01	149	целекоксиб	Celecoxib	капсул	200мг	Дилакса	C, D	том хүн	K56;K80;M11;M15;M16;M17;M18;M19;M45;N80	3838989656577	2,070	1035
656	M01AH01	149	целекоксиб	Celecoxib	капсул	200мг	Целеби	C, D	том хүн	K56;K80;M11;M15;M16;M17;M18;M19;M45;N80	8806625027217	620	434
657	M01AH01	149	целекоксиб	Celecoxib	капсул	200мг	Дилакса	C, D	том хүн	K56;K80;M11;M15;M16;M17;M18;M19;M45;N80	3838989656591	2,420	1210
658	M01AH01	149	целекоксиб	Celecoxib	капсул	200мг	Целебрекс	C, D	том хүн	K56;K80;M11;M15;M16;M17;M18;M19;M45;N80	1210001156630	4,230	1269
659	R06AE07	150	цетиризин	Cetirizine	бүрхүүлтэй шахмал	10мг	Аллетек Таб	A, B, C, D	том хүн	J31;L50;J01;J20;J21;J22;J39	8806472004322	150	75
660	R06AE07	150	цетиризин	Cetirizine	бүрхүүлтэй шахмал	10мг	Зодак	A, B, C, D	том хүн	J31;L50;J01;J20;J21;J22;J39	8594739055414	1,350	405
661	R06AE07	150	цетиризин	Cetirizine	бүрхүүлтэй шахмал	10мг	Зодак	A, B, C, D	том хүн	J31;L50;J01;J20;J21;J22;J39	8594739224605	1,000	300
662	R06AE07	150	цетиризин	Cetirizine	бүрхүүлтэй шахмал	10мг	Новакс Цетиризин	A, B, C, D	том хүн	J31;L50;J01;J20;J21;J22;J39	8964000326275	430	215
663	R06AE07	150	цетиризин	Cetirizine	бүрхүүлтэй шахмал	10мг	Цетиризин Протех	A, B, C, D	том хүн	J31;L50;J01;J20;J21;J22;J39	8901783002514	100	50
664	R06AE07	150	цетиризин	Cetirizine	бүрхүүлтэй шахмал	10мг	Цетиризин Протех	A, B, C, D	том хүн	J31;L50;J01;J20;J21;J22;J39	8901783004822	100	50

721	A02BC05	157	эзомепразол	esomeprazole	бурхуултэй шахмал	20мг	ЭСТА - 20	В, С, D	том хүн	K25;K29.3	8902399004299	380	190
722	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	10мг	Энап	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	3838989614966	390	117
723	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	10мг	Энап - нахиа	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	8656020767496	90	45
724	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	10мг	Энаф	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	8656020989072	210	105
725	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	20мг	Энап	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	3838989614973	470	235
726	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	20мг	Энап - нахиа	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	8656020767502	100	50
727	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	5мг	Энап	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	3838989614959	250	125
728	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	5мг	Энап - нахиа	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	8656020767489	75	53
729	C09AA02	158	Эналаприл	Enalapril	шахмал	5мг	Энаф	А, В, С, D	том хүн, хүүхэд	I10;I11;I12;I50;N03;N18	8656020989089	180	90
730	C09BA02	159	Эналаприл + Гидрохлоротиазид	Enalapril + Hydrochlorothiazide	шахмал	10мг+12.5мг	Энап-НЛ	В, С, D	том хүн	I10;I11;I12;I50;N03;N18	3838989606961	700	490
731	C09BA02	159	Эналаприл + Гидрохлоротиазид	Enalapril + Hydrochlorothiazide	шахмал	10мг+25мг	Энап-Н	В, С, D	том хүн	I10;I11;I12;I50;N03;N18	3838989606978	801	560
732	J05AF10	160	энтекавир	entecavir	бурхуултэй шахмал	0.5мг	Викюр	В, С, D	том хүн, хүүхэд	B18.1	8806429052512	1,870	1309
733	J05AF10	160	энтекавир	entecavir	шахмал	0.5мг	Энкавир	В, С, D	том хүн, хүүхэд	B18.1	8806454040218	2,430	1701
734	J05AF10	160	энтекавир	entecavir	шахмал	1мг	Энкавир	В, С, D	том хүн, хүүхэд	B18.1	8806454040416	2,409	1686
735	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	250мг	Порфиросин	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	5290931002500	300	150
736	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	250мг	Эрмицин	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	5290665001329	300	150
737	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	500мг	Эрибру 500	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	8902399005692	520	260
738	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	500мг	Эритромицин Протех-500	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	8934574091466	600	300
739	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	500мг	Эрмицин 500	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	5290665003163	650	195
740	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	500мг	Нивамицин 500	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	8904065004169	385	193
741	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	бурхуултэй шахмал	500мг	Эритромицин Протех-500	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	8901783004570	275	193
742	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	шахмал	250мг	Эритромицин Протех	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	8934574091633	300	150
743	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	шахмал	250мг	Эритромицин	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	5060013943713	140	70
744	J01FA01	161	Эритромицин	Erythromycin	шахмал	500мг	Эритро-БКРС	А, В, С, D	хүүхэд	H16;J40;L03	8908003345307	650	455

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл сонгох, үнийн дээд хязгаар хөнгөлөх хэмжээг тогтоох аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэх санал боловсруулахад энэхүү тушаалын хавсралтаар баталсан аргачлалыг баримтлах, уг аргачлалыг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд хүргүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Батчимэг)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны А/102 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газар (Б.Оюунцэцэг) -т даалгасугай.

ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ЗАЙЛШГҮЙ
ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН НЭР ТӨРӨЛ СОНГОХ, ҮНИЙН ДЭЭД
ХЯЗГААР, ХӨНГӨЛӨХ ХЭМЖЭЭГ ТОГТООХ АРГАЧЛАЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт (цаашид хөнгөлөлттэй эмийн жагсаалт гэх)-ыг шинэчлэх тогтоолын төслийг боловсруулахад энэхүү аргачлалын зорилго оршино.
- 1.2. Хөнгөлөлттэй эмийн жагсаалт нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - 1.2.1. Эмийн худалдааны нэршлийн дэс дугаар;
 - 1.2.2. Эмийн АТС код;
 - 1.2.3. Эмийн ерөнхий нэршлийн дэс дугаар;
 - 1.2.4. Эмийн олон улсын нэршил (монгол болон англиар);
 - 1.2.5. Эмийн хэлбэр;
 - 1.2.6. Савлалтын тун;
 - 1.2.7. Эмийн худалдааны нэр;
 - 1.2.8. Эмийг бичих эрхтэй эмчийн ангилал;
 - 1.2.9. Эмийг хэрэглэх хүн амын бүлэг;
 - 1.2.10. Өвчний олон улсын 10-р ангиллын код /ICD 10/;
 - 1.2.11. Эмийн бар код;
 - 1.2.12. Үнийн дээд хязгаар төгрөгөөр, ширхэгээр;
 - 1.2.13. ЭМД-ын сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээ, төгрөгөөр

**Хоёр. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орох эмийн нэр төрлийг сонгоход
баримтлах зарчим, эмийн жагсаалт боловсруулах үе шат**

- 2.1. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орох эмийн нэр төрлийг сонгохдоо Монгол улсын хүн амын дунд нийтлэг тохиолддог, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэл оруулдаг өвчин эмгэгийг эмчлэх эмнэлзүйн удирдамжид заасан эмийг сонгох үндсэн зарчмыг баримтална.
- 2.2. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг боловсруулах арга хэмжээ нь дараах үе шаттай байна. Үүнд:
 - 2.2.1. Монгол улсын хүн амын дунд нийтлэг тохиолддог, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлд оруулдаг өвчин эмгэгийг тодорхойлох;
 - 2.2.2. Сонгогдсон өвчин эмгэгийг эмчлэхэд шаардагдах эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох эмийн нэр төрлийг тодорхойлох;
 - 2.2.3. Эмийн үнийг тодорхойлох;
 - 2.2.4. Эмийн хөнгөлөлтийн хэмжээг тодорхойлох;
 - 2.2.5. Эмийн төсвийн тооцооллыг хийх;

2.2.6. Эмийн жагсаалтыг төсөвт багтаан эцэслэн тодорхойлох.

Гурав. Монгол улсын хүн амын дунд нийтлэг тохиолддог, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлд оруулдаг өвчин эмгэгийг тодорхойлох аргачлал

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээнийх нь эмэнд үнийн хөнгөлөлт үзүүлэх өвчин эмгэгийг сонгохдоо архаг өвчин, хурц өвчин, хүүхэд болон ахмад настанд зонхилон тохиолдох өвчин гэсэн үндсэн 4 бүлгийн дагуу энэхүү журмын 3.3 – 3.5-т тодорхойлсон аргачлалаар сонгоно.

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх өвчин эмгэгт дараах төрлийн өвчнүүдийг хамруулахгүй. Үүнд:

- Эмнэлэгт шууд хэвтүүлэн эмчлэх заалттай хурц эмгэг
- Шүдний өвчин эмгэг
- Гэмтлийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай өвчин эмгэг
- Амбулаториор эмчлэгдэхгүй халдварт өвчин зэрэг болно.

3.3. **Архаг өвчнийг сонгох аргачлал:** Архаг өвчнийг сонгохдоо Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан амбулаторийн үзлэгийн хамгийн сүүлийн оны мэдээллийг ашиглах бөгөөд онош бүрийг энэхүү журмын 3.3.1-т заасан шапгуураар үнэлж, түүнд харгалзах оноог өгнө. Нийт оноогоор 50% болон түүнээс дээш оноо авсан оношуудыг сонгоно.

3.3.1. Архаг өвчнийг сонгоход дараах шалгуур үзүүлэлт түүнд харгалзах оноог баримтлана. Үүнд:

Шапгуур 1. Амбулаторийн өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь - 30%

Шалгуур 2. Нас баралтын шууд шалтгаан болох эсэх - 30%

Шалгуур 3. Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдал - 30%

Шалгуур 4. Эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад нөлөөлөх байдал – 10%

3.3.2. Шалгуур үзүүлэлт 1 буюу “Амбулаторийн өвчлөлд эзлэх тухайн оношийн хуримтлагдсан хувь”.

3.3.2.1. Амбулаторийн өвчлөлд эзлэх тухайн оношийн хуримтлагдсан хувь-д харгалзах оноог өгөхдөө тухайн оношийн тоо хэмжээ нь амбулаторийн үзлэгийн нийт тоо хэмжээнд эзэлж буй хувиас хамааруулан ялгаатай онооны системээр үнэлж, оноог дараах томъёог ашиглан үндсэн онооны систем рүү шилжүүлнэ.

Амбулаторийн өвчлөлт эзлэх хуримтлагдсан хувьд ногдох оноо = Амбулаторийн үзлэгийн нийт тоо хэмжээнд эзлэх хувийн дагуу өгсөн оноо * 30%

3.3.2.2. Амбулаторийн өвчлөлд эзлэх тухайн оношийн хуримтлагдсан хувийг тодорхойлохдоо дараах нарийвчилсан шалгуур, түүнд харгалзах оноог

баримтлана.

Д/д	Шалгуурын нэр	Оноо
1	Хамгийн их давтамжтай нийт өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь (20 хувь хүртэл)	1 оноо
2	Хамгийн их давтамжтай нийт өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь (20-40 хувь хүртэл)	0.8 оноо
3	Хамгийн их давтамжтай нийт өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь (40-60 хувь хүртэл)	0.6 оноо
4	Хамгийн их давтамжтай нийт өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь (60-80 хувь хүртэл)	0.4 оноо

3.3.3. Шалгуур үзүүлэлт 2 буюу “Нас баралтын шууд шалтгаан болох эсэх”

3.3.3.1. Нас баралтын шууд шалтгаан болох”-д харгалзах оноог өгөхдөө тухайн оношийг нь Монгол улсын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчин эмгэгийн хэддүгээрт жагсаж байгаагаас хамааруулан ялгаатай онооны системээр үнэлж, оноог дараах томъёог ашиглан үндсэн онооны систем рүү шилжүүлнэ

Нас баралтын шууд шалтгаан болж буй эсэхэд ногдох оноо= Нас баралтын тэргүүлэх шалтгаанд хэддүгээр байрт орж буйд харгалзан өгсөн оноо * 30%

3.3.3.2. Тухайн онош нас баралтын шууд шалтгаан болж буй эсэхэд ногдох оноог тодорхойлохдоо дараах нарийвчилсан шалгуур түүнд харгалзах оноог баримтлана

Д/д	Шалгуурын нэр	Оноо
1	Зүрх-судасны тогтолцооны өвчин	1 оноо
2	Хавдар	0.8 оноо
3	Гэмтэл, хордлого, нас баралтын гадны шалтгаан	0.5 оноо
4	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	0.4 оноо
5	Амьсгалын тогтолцооны өвчин	0.2 оноо
6	Бусад	0.1 оноо

Шалгуур үзүүлэлт 3 буюу Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдал

3.3.4.1. “Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдал” -д харгалзах оноог өгөхдөө тухайн онош нь иргэдийг санхүүгийн эрсдэлд оруулж болохуйц шалтгаанаас нь хамааруулан ялгаатай онооны системээр үнэлж оноог дараах томъёог ашиглан үндсэн онооны систем рүү шилжүүлнэ.

Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдалд ногдох оноо = Санхүүгийн эрсдэлд оруулж буй шалтгаанд харгалзан өгсөн оноо * 30%

3.3.4.2. Тухайн онош нь иргэдийг санхүүгийн эрсдэлд оруулж буй шалтгаанд харгалзах оноог тодорхойлохдоо дараах нарийвчилсан шалгуур оноог баримтлана

Д/д	Шалгуурын нэр	Оноо
1	Байнгын хэрэглэдэг эмийг худалдан авах	1 оноо
2	Урт хугацаанд эдгэрэх хүртлээ эм худалдан авах	0.7 оноо
3	Гэнэтийн эрүүл мэндийн хэрэгцээ үүссэн үед тодорхой хугацаанд эм худалдаж авах	0.3 оноо

3.3.5. Шалгуур үзүүлэлт 4 буюу Эмнэлэгт хэвтэлтийг бууруулах байдал

- 3.3.5.1. “Эмнэлэгт хэвтэлтийг бууруулах”-д харгалзах оноог өгөхдөө тухайн онош нь амбулаторийн хяналтанд эмчлэгдэж болохуйц бөгөөд эмнэлэгт хэвтэлтийг бууруулж болохуйц шалтгаанаас нь хамааруулан ялгаатай онооны системээр үнэлж оноог дараах томъёог ашиглан үндсэн онооны систем рүү шилжүүлнэ.

$$\text{Эмнэлэгт хэвтэлтийг бууруулах байдлын ногдох оноо} = \text{Эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад нөлөөлөх байдлын оноо} * 10 \%$$

- 3.3.5.2. Тухайн онош нь эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад нөлөөлөх байдлын оноог тодорхойлохдоо дараах нарийвчилсан шалгуур, оноог баримтлана

Д/д	Шалгуурын нэр	Оноо
1	Амбулаториор эмчлэгдэх бүрэн боломжтой	1 оноо
2	Амбулаториор эмчлэгдэхэд тодорхой нөхцөл шаардагддаг	0.4 оноо

- 3.4. **Хурц өвчнийг сонгох аргачлал:** Хурц өвчнийг сонгохдоо Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан Амбулаторийн үзлэгийн хамгийн сүүлийн оны мэдээллийг ашиглах бөгөөд онош бүрийг энэхүү журмын 3.4.1-т заасан шалгуураар үнэлж түүнд харгалзах оноог өгнө. Нийт оноогоор 40% болон түүнээс дээш оноо авсан оношуудыг сонгоно.
- 3.4.1. Хурц өвчнийг сонгоход дараах шалгуур үзүүлэлт түүнд харгалзах оноог баримтлана. Үүнд:
- Шалгуур 1. Амбулаторийн өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь - 30%
 - Шалгуур 2. Нас баралтын шууд шалтгаан болох эсэх - 30%
 - Шалгуур 3. Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдал - 20%
 - Шалгуур 4. Эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад нөлөөлөх байдал - 20%
- 3.4.2. “Хурц өвчнийг сонгоход баримтлах Амбулаторийн өвчлөлд эзлэх хуримтлагдсан хувь”-д ногдох оноог энэхүү журмын 3.3.2-т заасан аргачлалаар тодорхойлно.
- 3.4.3. Хурц өвчнийг сонгоход баримтлах “Нас баралтын шууд шалтгаан болох эсэх”-д ногдох оноог энэхүү журмын 3.3.3-т заасан аргачлалаар тодорхойлно.
- 3.4.4. Хурц өвчнийг сонгоход баримтлах “Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдал”-ын шалгуур үзүүлэлт
- 3.4.4.1. “Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдал”-д харгалзах оноог өгөхдөө тухайн онош нь иргэдийг санхүүгийн эрсдэлд оруулж болохуйц шалтгаанаас нь хамааруулан ялгаатай онооны системээр үнэлж, оноог дараах

томъёог ашиглан үндсэн онооны систем рүү шилжүүлнэ.

Иргэдийг санхүүгийн эрсдэлд ороход нөлөөлөх байдалд ногдох оноо = Санхүүгийн эрсдэлд оруулж буй шалтгаанд харгалзан өгсөн оноо * 20%

3.4.4.2. Тухайн онош нь иргэдийг санхүүгийн эрсдэлд оруулж буй шалтгаанд харгалзах оноог тодорхойлохдоо дараах нарийвчилсан шалгуур, оноог баримтлана

Д/д	Шалгуурын нэр	Оноо
1	Өвчний эмчилгээнд уухаар хэрэглэх олон төрлийн эм хэрэглэгддэг байх ба санхүүгийн нэг удаагийн эрсдэл үүсгэх	1 оноо
2	Эмийн эмчилгээнд хэрэглэгдэх эмийн тоо маш цөөн	0 оноо

3.4.5. Хурц өвчнийг сонгоход баримтлах Эмнэлэгт хэвтэлтийг бууруулах байдал"-ын шалгуур үзүүлэлт

3.4.5.1. “Эмнэлэгт хэвтэлтийг бууруулах” -д харгалзах оноог өгөхдөө тухайн онош нь амбулаторийн хяналтанд эмчлэгдэж болохуйц бөгөөд эмнэлэгт хэвтэлтийг бууруулж болохуйц шалтгаанаас нь хамааруулан ялгаатай онооны системээр үнэлж оноог дараах томъёог ашиглан үндсэн онооны систем рүү шилжүүлнэ.

$\text{Эмнэлэгт хэвтэлтийг бууруулах байдлын ногдох оноо} = \text{Эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад нөлөөлөх байдлын оноо} * 20\%$
--

3.4.5.2. Тухайн онош нь эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад нөлөөлөх байдлын оноог тодорхойлохдоо дараах нарийвчилсан шалгуур оноог баримтлана.

Д/д	Шалгуурын нэр	Оноо
1	Амбулаториор эмчлэгдэх бүрэн боломжтой хэвтэлтэд шууд нөлөөлөх	1 оноо
2	Хэвтүүлэн эмчлэх шаардлагатай	0 оноо

3.5. Архаг болон хурц өвчинд тавигдах шалгуураар шүүгдэн сонгогдсон оношоос ахмад настан (55 ба түүнээс дээш настай) болон хүүхдэд (14 ба түүнээс доош) зонхилон тохиолдох өвчин эмгэгийг давхар шүүж ахмад настан болон хүүхдэд зонхилон тохиолдох өвчин эмгэг боловч архаг болон хурц өвчинд тавигдах шалгуураар сонгогдоогүй өвчин эмгэгүүдийг нэмэлтээр сонгоно.

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох эмийн нэр, төрлийг тодорхойлох

4.1. Эмийн жагсаалтад дараах шалгуурыг нэгэн зэрэг хангасан эмийг оруулна.

4.1.1. Энэхүү аргачлалын гуравдугаар бүлэгт заасан шалгуурыг хангасан өвчинд хэрэглэдэг байх;

4.1.2. Олон улсад ашиглагддаг эмнэлзүйн удирдамжийн эмчилгээнд заагдсан байх;

4.1.3. Монгол улсын эмийн бүртгэл болох LICEMED системд бар кодтойгоор бүртгэгдсэн байх;

4.1.4. Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад ерөнхий нэршил, тун хэмжээ, хэлбэр багтсан, нийтийн үйлчилгээтэй эмийн сангаас жороор олгох тарилга болон дуслын тарилга шингэнээс бусад эмийн хэлбэрээр байх;

4.1.5. Гаалийн ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын сүүлийн 3 жилийн эмийн импортын мэдээлэлд үнийн мэдээлэл нь үнэн зөв бүртгэгдсэн байх;

Тав. Эмийн үнийн дээд хязгаар тогтоох

5.1. Эмийн үнийн дээд хязгаарыг тодорхойлохдоо эмийн гаалийн үнэ, дотоодын үйлдвэрлэлийн үнэ, эмийн зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, гадаадын улс орнуудын жишиг үнэ, эмийн үйлдвэр, олон улсын эмийн үйлдвэрийн төлөөлөгчийн газар, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, эмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгдсэн холбооны албан ёсны үндэслэл бүхий санал, Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн төвийн мэдээний санд бүртгэгдсэн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтад тусгагдсан нэгжийн үнэ, борлуулалтын тоо хэмжээг ашиглан дараах томъёоллын дагуу тооцно. Үүнд:

5.1.1. Импортын эмийн үнийн дээд хязгаарыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$P = (((Ctp * Vc) * (1+Ct)) * (1+Vat)) * (1+Wm) * Wc * (1+Rm) * Ac$$

5.1.2. Дотоодын үйлдвэрлэлийн эмийн үнийн дээд хязгаарыг дараах томъёоллын дагуу тооцно.

$$P = (((Ip * Infc) * (1+Vat)) * (1+Wm) * Wc * (1+Rm) * Ac$$

P = Үнийн дээд хязгаар

Ip = Үйлдвэрлэлийн үнэ

Ctp = Гаалийн үнэ

Vc = Ам долларын төгрөгтэй харьцах ханшийн коэффициент

Infc = Инфляцын тохируулагч коэффициент

Ct = Гаалийн татвар

Vat = Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь

Wm = Бөөний үнийн нэмэгдэл хувь

Wc = Тээврийн зардлын бүсийн коэффициент

Rm = Жижиглэнгийн үнийн нэмэгдэл хувь

Ac = Эмийн хүртээмжийн тохируулагч коэффициент

- Гаалийн үнийг (Ctp) Гаалийн ерөнхий газар болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын эмийн импортын мэдээлэлд үндэслэн үйлдвэрийн үнэ, Монгол улсын хилийн боомт хүртэлх тээврийн зардал болон, тээвэрлэхтэй холбоотой зардлыг шингээсэн байдлаар тооцно.
- Үйлдвэрийн үнийг (Ip) Монгол улсад эмийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудаас ирүүлсэн холбогдох санхүүгийн баримтад үндэслэн тооцно.
- Ам долларын төгрөгтэй харьцах ханшийн коэффициент (Vc), Инфляцын тохируулагч коэффициентийг (Infc) Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээлэлд үндэслэн тооцно.

- Тээврийн зардлын бүсийн коэффициент (W_c) нь Монгол улсад импортоор орж ирдэг эмийг УБ хотоос түгээж буй нь УБ хотоос алслагдмал орших орон нутгийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд алслагдсан орон нутагт ижил тарифаар санхүүжүүлж буй нь нэмэгдэл бүхий бүтээгдэхүүнээр үйлчилж буй хөдөөгийн ЭМБ-уудын үйл ажиллагаанд тодорхой хүндрэлийг бий болгож байна.

№	Бүсчлэл	Тээврийн зардлын коэффициент
1	Баруун бүс	1.15
2	Хангайн бүс	1.1
3	Төвийн бүс	1.05
4	Зүүн бүс	1.05
5	Улаанбаатар	1

- Эмийн хүртээмжийн тохируулагч коэффициент (A_c) нь тухайн бүс нутагт хүн амын тоотой харьцуулан эмийн сангийн хүртээмжийг тодорхойлно.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын хувийг (Vat) холбогдох хуульд заасны дагуу нэмэгдүүлэн тооцно.
- Бөөний үнийн нэмэгдэл хувь (W_m), Жижиглэнгийн үнийн нэмэгдэл хувийг (R_m) Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батална гэж заасны дагуу тухайн тушаалаар баталсан хэмжээгээр нэмэгдүүлэн тооцно.

5.2. Нэг эх үүсвэрийн худалдан авалтын хүрээнд нийлүүлэгдсэн эмүүдийн үнийн дээд хязгаарыг холбогдох гэрээ болон бусад бичиг баримтад үндэслэн тогтоох ба энэхүү аргачлалын 5.1.1-д заасан томъёоллын дагуу тооцно.

5.3. Эмийн үнийн дээд хязгаарыг бутархайгүй дүнгээр илэрхийлнэ.

Зургаа. Эмийн үнийн хөнгөлөлтийн хэмжээг тогтоох

6.1. Эмийн үнийн хөнгөлөлтийг даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, зах зээл дэх эмийн үнийн өсөлтийг бууруулах, боломжийн үнэтэй, чанартай эм, женерик эмийн хэрэглээг дэмжих, хөнгөлөлтийн хэмжээ нь үнийн тархалт, үнийн интервалаас хамаарч ялгаатай байх, эмийн үнэ буурсан тохиолдолд хөнгөлөлтийн хувийг нэмэгдүүлэх, нэг эмийн нэршил, хэлбэр, тунгийн ангилалд хамаарах эмүүдээс даатгуулагч үнэтэй эм сонгосон тохиолдолд илүү хамтын төлбөр төлөх зэрэг зарчмыг баримтлан дараах нарийвчилсан зохицуулалтын хүрээнд тооцооллыг хийж тодорхойлно. Үүнд:

6.1.1. Хөнгөлөлтийн хэмжээг тогтоохдоо олон удаагийн хэрэглэх эм, нэг удаагийн хэрэглэх эмүүдийг бүлэглэн тухайн бүлэг тус бүрийн тооцооллыг тусад нь хийнэ.

- Олон удаа хэрэглэх эм гэдэгт нэг удаагийн худалдан авалтаар олон удаа хэрэглэдэг, ширхэглэж борлуулах боломжгүй, нэг удаагийн эмчилгээний тунг нийлүүлэн савласан эмийг хамруулан авч үзнэ.
- Нэг удаагийн хэрэглэх эм гэдэгт ширхэгээр борлуулах боломжтой, нэг удаагийн эмчилгээний тунг тус тусад нь савласан эмийг хамруулан авч үзнэ.

6.1.2. Тухайн бүлэгт байх эмийн хөнгөлөлтийн хэмжээ нь үнийн интервалаас хамаарч дараах байдлаар хүснэгтад заасны дагуу тодорхойлогдоно.

Хүснэгт 1. Олон удаагийн хэрэглэх эмийн хөнгөлөлтийн хувь

№	Үнийн хүрээ /төг-өөр/	Хөнгөлөлтийн хувь
1	0-5,000	80%
2	5,000-10,000	70%
3	10,000-30,000	60%
4	30,000-40,000	50%
5	40,000-аас дээш	40%

Хүснэгт 5. Нэг удаагийн хэрэглэх эмийн хөнгөлөлтийн хувь

№	Үнийн хүрээ /төг-өөр/	Хөнгөлөлтийн хувь
1	0-200	80%
2	200-350	70%
3	350-700	60%
4	700-2,000	50%
5	2,000-аас дээш	40%

6.1.3. ЭМД-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 - 6.1.8 заасан хүн амын бүлэг заасан иргэний хамтын төлбөрт төлж буй жилийн мөнгөн дүн нь тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин үржсэн дүнгээс давсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас үндсэн хөнгөлөлт дээр нэмэгдүүлэн 90 хувиар хөнгөлөлтийг ялгаатай байдлаар тогтоож болно. Энэхүү жагсаалтыг жил бүр эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт ирсэн эмийн үнийн хөнгөлөлтийн мэдээлэлд үндэслэн тооцоолж гаргана.

6.1.4. Нэг эх үүсвэрийн худалдан авалтын хүрээнд нийлүүлэгдсэн эмүүдийн хөнгөлөлтийн хувийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан тогтоох ба тооцооллыг хийхдээ энэхүү аргачлалын 6.1.2-д зааснаас ялгаатай байдлаар буюу эмийн үнийн хүрээг өөрөөр тогтоож болно.

Долоо. Бусад

7.1. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим санд эмийн жагсаалт дахь ерөнхий нэршлийн бүртгэлийн дугаар, АТС код, эмийн худалдааны нэршлийн дугаар бүхий дугаарын нэгдэл нь кодлогдох бөгөөд мэдээ, тайлан судалгаа гаргахад ашиглана.